

# Манмин Мэдээ

№ 70 2019 оны 3 сарын 24

Гадаадаас ирсэн захидал



2019.1.2. Аргентинаас  
Кристиан Езекул Салас итгэгч

Зжилийн өмнө эхнэр маань гуравдах хүүхдээ тээж байхдаа 28дахь долоо хоног дээрээ цусны даралт ихсэж, үүний улмаас хэвлий дэх ургийн ихэс ховхорч амьгүй ураг төрүүлсэн юм. Дотуур цус алдалтаас болж савны хагалгаанд орох шаардлагатай болсон ба эхнэрийн маань амь нас аюултай байдалд орсон юм.

## “Гуравдахь хүү Бенхамин минь төрөөд нэг сар боллоо”

2018оны эхээр дахин жирэмсэлж эмнэлэгт үзүүлгэл 12долоо хоног хүртэл тэсч үлдэхэд амар биш нөхцөлд байна гэсэн юм. Учир нь эхнэр минь байнга цусны даралт ихэддэг, цус өтгөрөлттэй байсан юм. Мэргэжлийн эмнэлэг санал болгосон ба тийшээ нь очиход эх болон урагын амь насанд аюултай тул эмчилгээ хийхээс татгалзсан юм. Бид ч буцан анх үзүүлсэн эмнэлэг рүүгээ дахин очиж, эмчилгээ хийж өгөхийг гуйхад эмч усан эмчилгээний хамт маш чанд анхааруулгыг өгч байлаа.

Тэгж байтал би Аргентин Манмин гэр цуглаанд сууж үзсэн юм. Эхнэр минь энд ирэх хол байсан ч 2018он 3-р сард бүх гэр бүлээрээ мөргөлд оролцож, дэлгэцээр И Жей руг тэргүүн пасторын цаг орон үл хамаарах эрх мэдэлт хүчтэй залбирлыг авсан юм.

Би тэргүүн пасторын залбирлыг авсан болохоор эхнэр ба хүүхдийг минь Бурхан хамгаалж өгнө гэдэгт итгэсэн юм. Жирэмсэний

бсартайд ч бүх зүйл хэвийн байсан ба хүүхэд ямар ч асуудалгүй төрнө гэсэн юм. Гэтэл 8сартайд нь эхнэрийн цус нөжрөлт эхэлж маш ноцтой цус багадалттай болж, байнга цус сэлбэх хэрэгтэй болсон ба дайран дээр давс гэдэг тэр эмчилгээ ямар үр дүнгүй байлаа.

Тиймд залбирал авбал, Бурханаас зууран гуйсан тул эхнэр маань эргээд хэвийн байдалдаа орсон юм. Эцэст нь Бурханы хүч нөлөөгөөр эхнэр минь тайван амаржсан юм. Хүүхэд минь жингийн алдагдалтай төрсөн ч маш хурдан жиндээ хүрч, эрүүл цовоо өсөж бойжиж байгааг эмч нар хараад гайхаж байлаа. Эхнэр маань хурдан тэнхэрч гэрийнхээ ажлыг болон гурван хүүгээ сайн харж байгаа.

Аргентинаас И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлаар дамжуулан, ийм гайхамшгийг бүтээсэн Агуу Бурхандаа талархалыг өргөөв Энэ бүх зүйл хайрт Эзэний минь ивээл билээ.

## “Хэрцгий нөхөр гэдэг үг хуучирч, одоо сайхан гэр бүл болсон нь”

Сун Ги жү (Сүмд үйлчлэгч, 75нас)



Өмнө нь миний бүх зүйл сайн болж өгдөггүй байлаа. Хийсэн ажил болгон минь сайн болж өгөхгүй хүнд хэцүү амьдралд нухлагдсаар сэтгэл минь бага багаар хатуурсаар байлаа. Эхнэр хардаж шинэхэн гэрлэснийхээ дараахан архинд орж, эхнэртэй эргэлзэн, элдэв хараал хэлж, гар хүрч, дотор давчдан хоол ч идэх дургүй болж хоолны ширээг хөмөрч хаях нь ердийн үзэгдэл тул эхнэр минь ганихрах өвчнөөр шаналж байгаа нь мэдээжийн байлаа.

2004оны 5-р сард эхнэр бид 2Сөүлд цайны газар ажиллуулдаг том хүүдээ туслахаар Сөүлд ирэн хамт амьдрах болсон юм. Амьдралдаа сүмийн хашаанд ойртож үзээгүй ч манай том бэр (Жон Гёон хи сүмд үйлчлэгч) сүм рүү хамт явъя гэхэд нь шууд л дагаад явлаа.

И Жей руг тэргүүн пасторын сургаалийг

сонсож үзтэл Бурханы үг ойлгоход амархан, бас сонирхолтой, сүмд ирэхэд хүртэл сэтгэл сайхан байв. Тэгээд сургааль сонссоор байтал эхнэрээсээ уучлалт гуйж, архи, тамхиа хаяж зөөлөн таатай нөхөр болъё гэж шийдсэн юм.

Тэгээд эхнэр минь ганихрах өвчнөөсөө эдгэрч, өвчин залбирлаар 10жил болсон арьсны өвчнөөсөө хүртэл бүрэн эдгэрч, би ч дотрын өвчнөөсөө эдгэрсэн юм. Халлелүя!


### Амьдрал эрс өөрчлөгдсөн хүч нөлөө

Амьдралын амт инээд баясалыг эргээд олсон бид гэр бүл мэт Гандун салбар танхимын итгэгч нартаа жижигхэн аз жаргалыг түгээхийг хүссэн юм. Би бие муутай эсвэл өндөр настай итгэгч нарын төлөө машинаар үйлчилж, хоол сайн хийдэг эхнэр маань Эзэний өдөр болгон амтат хахируудыг бэлдэн чин сэтгэлээсээ үйлчилж байлаа.

Тэгж байгаад 2016оны сүүлээр өмнө хийж байсан мужааны ажлаа дахин хийж эхэлсэн ба барилгын талбар дээр 5давхар дээрээс унах шахаж маш аюултай осолд орсон юм.

Барилгын 5н давхарын гадна талд ажиллаж байтал хураалттай байсан хөндөл мод толгой дээрээс унахад би тэндээ ухаан алдан унасан байлаа. Цутгалтын хана угсарч багласан арматур төмрийг түшин ажиллаж байсан би муужран унахдаа гишгэж байсан хөндлөн төмөр дээр биеэрээ тогтоход хэцүү байсан ч гайхалтай нь дээрээс бас нэг хөндөл мод унаж бие дээр тогтсоноор доош уналгүй үлдсэн байсан юм. 10орчим минутын дараа хамт ажиллаж байсан хүмүүс намайг буулгаж авсан юм. Эмнэлэгт очин зураг авахуулж шинжилгээ хийлгэтэл толгой болон хөл ямар ч асуудалгүй хэвийн байлаа.

Хамт ажилладаг нэг маань “Өглөө болгон тэргүүн пасторын залбирлыг авч ажилладаг



болохоор үнэхээр Бурхан хамгаалж өгчээ!” гэж Бурхандаа алдрыг өргөж байлаа.

2018он илүү сайхан гэртэй болох ерөөл авч, 2019онд шинэ онд 75настай ч шинэ ажилд ороод эрч хүчтэйгээр ажиллаж байна.

Энэ бүх зүйл амьд оршигч Бурхантай уулзсаны дараа бий болсон ба миний амьдралд эрс өөрчлөлтийг авчирсан юм. Эрүүл байвал наяд наслана гэдэг шиг энэ газар дээр ч тэнгэрийн орны тэмүүлэл дотор эрүүл энх, баяр хөөртэйгөөр амьдрахаар ерөөж өгсөн Бурхандаа бүх талархал ба алдрыг өргөө.

# Амар тайванд таригддаг зөвийн үр жимс

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кеонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Хэрэв хажууд хүн тань маш айхтар уурлавал ухаалаг хүн бол яах байсан бол? Улам уурыг нь дэвэргэх үг ба үйлдэл хийдэггүй. Тэгэхгүй бол гал руу тос цацах мэт байдал улам ширүүсэж болзошгүй юм.

Гэтэл аар саар асуудлаас болж маргалдсанаас болж, тавгүйрхэж, “Хоёулаа салъя” гэх үгийг эргэлзэлгүй хэлдэг гэр бүлийн хоёр ч байдаг. Ямар ч нөхцөл байдалд бусдыг ойлгож, хамгаалж өгөн цайлган үг үйлдлээр бүгдтэй эвтэй байхын тулд яах ёстой вэ?

## 1. ‘Амар тайвныг бүтээгч’ гэж Бурханы өмнө амар тайвныг суулгадаг нэгэн

Иаков 3:17д гардаг ариун, амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй эдгээр мэргэн ухааныг бүрэн эзэмших үед 18-р ишлэлд гардаг ‘Амар тайвныг тогтоогч’ болдог. Энэ нь ‘Бурхантай эвтэй байх’ буюу Бурхан ба бид хоёрын дунд гэрийн хана байхгүй хүнийг хэлдэг. Ингэж Бурхантай эвтэй байж, амар тайвныг суулгагч нь зөвийн үр жимсийг хурааж авдаг.

Хүмүүс хааяа үнэнийг зөрчин ёс бус, хууль бус зүйлтэй нийлэхийг ‘Эв нэгдлийг биелүүлэх ухаан’ гэж андуурах үе бий. Заримдаа хүмүүсийн харилцаанд ашиг сонирхолоос болж, Бурханы үгийг зөрчих тохиолдол ч гардаг. Элбэг тохиолдох жишээ бол зээлийн батлан даалт бичих, элдэв мөнгөтэй холбоотой асуудал юм.

Библид “Бусдын өрийн төлөө батлан даалт гаргадаг хүн байх хэрэггүй” (Сургаалт үгс 22:26), “Нэг нэгэндээ хайртай байхаас өөр хэнд ч ямар ч өргүй бай” (Ром 13:8) гэсэн байдаг. Гэтэл маш ойр дотны хүн “Батлан даагч болоод өгөөч” “Эргэлтийн хөрөнгө зээлээд өг”, гэвэл Бурханы үгийг орхин дуулгаваргүй ханддаг хүмүүс ч байдаг. Итгэлийн ах дүүс туслаач гэвэл бүр татгалзаж ч чадахгүй биз дээ.

Энэ нь өөртөө л хүнд байдлыг авчрах явдал юм. Буцааж авахгүй гэвэл өөр ч тийм л биш бол тэгж байгаад хүнд байдалд орвол бие биетэйгээ дайсагналцах явдал ч гарч болзошгүй юм. Хүмүүстэй эвтэй байхыг Бурхантай эвтэй байхаас илүүд үзсэн болохоор ийм байдалд хүргэдэг. Түүнчлэн өөрийн эрх ашгийг хайн урвах болон Бурханы алдрын төлөөх эвтэй байдлыг сайн ялгадаг байх хэрэгтэй юм.

Бага балчир өсвөр насандаа Даниел болон түүний гурван найз Вавилон руу боол болон аваачигдсан юм. Хэдийгээр боол ч гэсэн Бурханы үгийн дагуу амьдаръя гэсэн тэднийг Бурхан дэмжиж байлаа. Гэтэл нэгэн өдөр хааны үйлчилж мөргөдөг алтан шүтээнд мөргөхгүй бол галт зууханд хаяна гэсэн юм. Тэд хаантай эвтэй байхын тулд тэр шүтээнд нь мөргөвөл л болоо юм. Гэтэл Бурханы өмнө том гэм нүгэл бөгөөд Бурхантай эв түнжин хагарах үйлдэл тул тэд амиа алдаж болох нөхцөлд ч хаан бус харин Бурхантай эвтэй байх талыг сонгосон юм.

Үүний үр дүнд Бурхан тэдний зөвт үйлсийг агуу ихээр илрэн харуулсан юм. Уурлаж хилэгнэсэн хаан тэднийг шатаах зуухыг ердийнхөөс долоо дахин халуун болгож түүндээ Даниел ба гурван найзыг нь хийсэн ч огт хохирол амсалгүй, үс нь ч хуйхлагдаагүй байсан юм. Ийм гайхамшигийг үзсэн Вавилоний

хаан Бурханыг агуу ихээр алдаршуулж, тэдний байр суурийг нь өсгөж өгсөн юм (Даниел 3-р бүлэг).

Энэ мэт Бурхантай эвтэй байдлыг хадгалсан Даниел ба түүний гурван найз Бурханы гайхалтай ерөөлийг авсан төдийгүй Бурхан ба хүмүүсийн хооронд ‘Амар тайвныг бүтээгч’-н үүргийг гүйцэтгэсэн юм.

## 2. Бурханыг харахад зөвийг үйлддэг байж амар тайвныг бүтээдэг нэгэн

Египетээс гарсан нь 15:26д “Хэрэв та нар өөрсдийн Бурхан ЭЗЭНий дуу хоолойг анхааралтай сонсож, Түүний мэлмийд зөвийг үйлдэж...” гэж айлдсан шиг хүнийг харахад зөвт үйлс ба Бурханыг харахад зөвт үйлс нь өөр зүйлс юм.

Жишээ нь Ихэнхи нь “Өшөөгөө, хариугаа авах нь шударга зөв явдал” гэдэг бол Бурхан бүх хүмүүсийг хайрлан, дайснаа ч хайрлахыг зөвт үйлс гэдэг. Хүмүүс эцсээ хүртэл өөрийн итгэл үнэмшилдээ үнэнч бат байхыг зөв гэдэг бол Бурхан өөрийгөө харахад зөв зүйлээр дамжуулан бусад эв түнжин хагалдаг хүнийг зөв зүйл хийлээ гэдэггүй байна.

Энгийн үгээр ертөнцөд бол үзэн ядалт уур уцаар, атаархал, маргаан, завхайрал, шунал, зэрэг зүрх сэтгэлд маш их хорон муу байгаа үйлдлээр хийхээс өмнө ёс бус, эсвэл гэмтэй гэдэггүй. Гэтэл Бурханы хувьд үйлдлээр хийгээгүй ч зүрх сэтгэлд хорон муу байгаа л бол энэ нь ёс бус болон гэм нүгэл юм.

Энэмэтчилэн хүний бодож буй зөв ба Бурханы айлдаж буй зөв нь өөр өөр байдаг. Библи дээр ‘Хий, Бүү хий, Сахь, Хая’ гэсэн үгийн дагуу өө сэвгүй болтол үйлдэх нь л Бурханыг харахад зөв үйлс юм (Номлогчын үгс 12:13). Гэвч ихэнх хүмүүс өөрийгөө харахад зөв талыг сонгох олонтаа байдагыг харж болно.

Сургаалт үгс 16:7д “Хүмүүний зам Эзэний таалалд нийцэх цагт Тэрээр түүн дайснуудыг нь хүртэл түүнтэй эв түнжинтэй байлдадаг” гэсэн байдаг. Энэ мэт Бурхантай эхлээд эвтэй байснаараа хүмүүстэй ч эвтэй байх болдог. Хэрэв Бурхантай эв түнжин хагарч, хүмүүстэй эв байлаа ч тэр хэзээ нэг өдөр хагарч болзошгүй тул эцэстээ ямар ч үр дүнгүй юм.

Ижилхэн нэг л гэрт тахилын ширээний өмнө мөргөөгүй ч гэсэн ямар мэргэн ухаанаар үйлдэхээс шалтгаалан үр дүн нь өөр болдог. Ариун Сүнсний тусламжтайгаар сайны болон мэргэн ухаалаг үгээр итгэдэггүй гэрийнхнээ ятгаж болвол сайн ч гэсэн тийм нөхцөл бүрдээгүй бол харин ч чимээгүй байсан нь дээр байдаг. Чимээгүйхэн залбирмагцаа тууштай байдлаар Бурханы өмнө сайныг үйлдсэнээр зохистой цаг нь ирвэл гэр бүлдээ авралын зар тараах боломж ч ирдэг.

Зарим хүн сэтгэлдээ түргэдэж, өөрөө түрүүлж хийж байгаад бүтэлгүйтэх тохиолдол бий. Үгээр хүчлэн өөрийн санал бодлыг тулгах, эсвэл тавгүйтэл агуулсан үгээр гэрийнхэнтэйгээ маргалдах зэргээр гэрийн бүлийн хүмүүсийн сэтгэлийг шархлуулдаг. Өөрийнх нь зөв байсан ч өөрийн үзэл бодолдоо хэрэгцээгүй үйлдэл гаргаснаас болж илүү том сорилтонд унавал тэр бол мэргэн ухаан биш юм.

## 3. Эв нэгдлийг суулган зөвийн үр жимсийг авахын тулд

Үйлс номын 7-р бүлэгт гардаг Стефан сүмд үйлчлэгч


### Монгол Манмин Сүм

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

#### Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



**Хаяг:** Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг  
**Утас:** 88107327, 91170773, 89737773

www.manmin.org  
www.gcntv.org

нь өөр лүү нь чулуу шидэж буй хүмүүсийн төлөө залбирч өгөх хэмжээний хорон муугүй хүн байсан юм. Гэсэн ч чулуугаар шидүүлж амиа алдсан нь тэрээр хүмүүсийн алдаа дутагдлыг зэмлэсэнээс болсон юм. Тэрээр зөвт сэтгэлээр үнэн зөвийг хэлсэн ч атгаг хүмүүсийн үүднээс өөрсдийг нь өдөөн хатгасан тэсэхийн аргагүй байдалд оруулсан байдаг. Тэр нь мэдээж Бурханы өмнө зөвт үйлс хэдий ч тийм нөхцөлд ухаалгаар зайлсхийх замыг хайсан бол амиа алдалгүй илүү ихээр үйлчлэн Бурхандаа алдрыг өргөх боломжтой юм.

Есүс бүх үг хэл яриандаа маш төгс бөгөөд хэн нэгэнд олзлогдох хэмжээний үг яриа ярилгүй, хэнтэй ёс бус харьцдаггүй байв. Маш олон ажил хийсэн ч асуудал үүсгэлгүй, эргэн тойрноо амар амгалан байлдаг байв. Эсрэгээрээ бид Бурханы хайрлаж, зөвийг үйлдэж байна гэсэн ч үг үйлдэл минь төгс байж чадахгүй хэмжээгээр бусдыг сэтгэлийг өвтгөх юм уу шархлуулдаг.

Тийм ч учраас Есүс хэрхэн үйлдэж байсныг санан ухаалаг хариултыг олох хэрэгтэй юм. Бурханы хүсэлд нийцтэй талыг сонгох төдийгүй арга ухаан байсан ч сайны мэргэн ухаанаар хариултаа авч бүх хүмүүстэй эвтэй байх боломжтой юм. Гэм нүгэлгүй Есүс загалмай дээр цовдлогдон нас барснаар эвлэрүүлэл болж өгсөн тул хэн ч итгэлээр Бурханы хүүхэд болох эрх мэдэлтэй болж, эвлэрэх болсон юм.

Ром 5:1д “Тиймээс итгэлээр зөвтгөгдсөн бид бидний Эзэн Есүс Христээр дамжуулан Бурхантай эвлэрсэн билээ” гэсэн байдаг. Бурхантай эвтэй байхын тулд яах ёстой вэ? Гэмээсээ уучлагдлаа гээд тэгээд дуусах бус итгэлээр зөвтгөгдвөл үйлстэй жинхэнэ итгэлээр өсөх хэрэгтэй юм. Маш хурдан бүх л хорон муу зан чанараа хаян, Бурханы зөвийг биелүүлэх хэрэгтэй юм. Харин ийм үйлстэй итгэлээр өсөж бойжиж чадахгүй урьдын адил гэм дотор амьдарвал Бурхан эв нэгдэл хагарах болдог.

Бурхан цор ганц Хүүгээ хайрлалгүй зориулах хүртэл бүх зүйлээ золиосолж, бидэнтэй эвлэрсэн юм. Тиймд итгэлээр гэмийн уучлалтыг авсан бол цаашид эв нэгдэл хагалах явдал гаргахгүй Бурханыг харахад зөвийг үйлдэн үргэлж Бурхантай эвтэй байх төдийгүй бага багаар итгэлцэх харилцааг бий болгож итгэлийн өвөг Абрахам шиг зөвт байдлын үр жимсээр дүүрэн байх болно.

#### 4. Амар тайвныг бүтээгч нэгэнд ирэх ерөөл

Итгэлийн өвөг гэж нэрлэгдэх Абрахам нь Бурханыг харахад үзэсгэлэнтэй олон хүмүүсийг өвөрлөж чадах сэтгэлтэй байлаа. Нэг удаа Абрахам Абимелехийн боолууд түүний ухсан худгуудийг булаасан тухай Абимелехт мэдүүлж түүнийг зэмлэдэг. Гэтэл Абимелех энэ талаар огт мэдээгүй байсныг олж мэдээд цаашлан хариуцлага нэхээгүй

юм. Түүнийг эвгүй байдалд оруулах эсвэл нөхөн төлбөр авах гэсэндээ бус зөвхөн тухайн байдлыг мэдүүлж, цаашид ийм явдал дахин гаргахгүй байхын төлөө байлаа.

Абрахам худагын асуудлаас болж дахин буруу ойлголцолд хүрэхгүйн тулд хонь ба үхрийг Абимелехт өгч хоорондоо гэрээ байгуулдаг. Зэмлэсэн ч эв нэгдлийг хадгалж, эв түнжинтэйгээр тус тусын газраа тэмдэглэсэн юм. Боолуудынхаа буруутай байдлын хариуцлагыг үүрч нөхөн төлбөр гаргах ёстой байсан Абимелех Абрахамын худгын үнийг төлж, мөн чин сэтгэлээсээ уучлалт гуйсан юм. Үүнээс хойш түүний боолууд дахин ийм явдал гаргаагүй юм (Эхлэл 21-р бүлэг).

Абрахам нь сайны мэргэн ухаанаар бүх ажлаа маш цэвэр шийдсэн юм. Бүх хүнтэй эвтэй байсан төдийгүй цаашлаад ямар ч асуудал үүсэхээргүй төгс шийддэг байв. Ингэж эвтэй байдлын ухааныг олвол Бурханы хаанчлалын ажилд маш их үр нөлөөтэй байдаг. Заримдаа өөрийг нь эсэргүүцдэг хүнийг ч гэсэн сайн мэргэн ухаанаар түүний сэтгэлийг олвол өөрийг нь эсэргүүцэх бус тусладаг дэмждэг хүн болгох боломжтой. Ийм сайны ухаан нь өөрийгөө зориулж чадах уужим сэтгэл болон хувиа бодох зүйлгүй шудрагаар үйлдэх үед л өгөгдөх болдог.

Мөн Абрахам нь бүх үйлстээ хуурмаг бус үнэнч сэтгэлтэй юм. Бурханы хүсэл л юу байсан дуулгавартай дагах чин сэтгэл байсан тул Бурхантай эвтэй байв. “Чи төрсөн нутаг, төрөл садангаа, эцгийгээ гэрийг орхиод Миний зааж өгөх газар руу яв” гэхэд эргэлзэх эсвэл сэтгэлээр уналгүй тэрчлэн шууд дагасан юм (Эхлэл 12-р бүлэг). Ийм сэтгэлтэй тул Бурхан түүнд Исаакаар дамжуулан түүний үр удмыг тэнгэрийн одод мэт, далайн эргийн элс мэт олон болгоно гэж амласан юм.

Бурхан Абрахамын 100настайдаа олсон ганц хүүгээ мал амьтан шиг тахилаар өргө гэхэд ч Абрахам үхэгсдээс ч амилуулах чадалтай Бурханд төгс итгэж байсан тул огт тээнгэлзэлгүй дуулгавартай дагасан юм. Энэ мэт дуулгавартай дагах сэтгэлтэйг мэдэж байгаа Бурхан тахилаар өргөх Исаакийн оронд нэгэн хонийг бэлдсэн байсан юм (Эхлэл 22-р бүлэг).

Абрахам нь зөвхөн үгэнд дуулгавартай байсан тул Бурхан түүнтэй үргэлж хамт байж, явсан газар болгондоо ерөөгдөж амжилтгаар дүүрэн байлаа. Бурхантай эв түнжинтэй хүн нь бусад хүмүүсийг ч Бурхантай эвтэй байлгахад хөтөлж өгдөг. Абрахам нь Бурхантай эвтэй байснаараа түүнтэй хамт байсан Лот мөн ерөөгдсөн юм.

Мөн Египэтээс удирдан гаргасан Мосегийн улмаас Израйлийн ард түмэн Бурханы уучлалтыг авч хайр ивээлийг хүртсэн юм. Цөлд Израйлийн ард түмэн тавгүйтэж, алтан тугал хийж тэрэндээ

мөргөх зэрэг Бурханы өмнө маш гэм үйлдэх үед өөрөө там руу явсан ч хамаагүй тэднийг аварч өгөөч гэж Бурханаас гуйсан байдаг (Е. Гарсан нь 32:31-32).

Энэ мэтчилэн олон хүмүүсийг Бурхан руу удирдан эвтэй байлгах үед л Бурханы жинхэнэ хүүхэд гэх боломжтой юм. “Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй еэ. Учир тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно” (Матай 5:9) гэсэн үгийн дагуу юм.

Иосеф нь харь улсад боолоор худалдагдаж, хилсээр гүтгэгдэн шоронд орохдоо ч Бурханд найдаж итгэмжтэй байдаг байв. Бурхан ийм түүнд Египетийн фараоны зүүдийг тайлах чадварыг өгсөн юм. Тэр зүүд нь хожим Египетэд 7жилийн турш болох ургац арвин байдал ба 7жилийн турш өлсгөлөн болохын сануулга байлаа. Мөн төдийгүй Бурхан Иосефт энэ өлсгөлөн хэрхэн даван туулах мэргэн ухааныг ч өгсөн байв. Үүний улмаас Иосеф Египетийн ерөнхий сайдын байр сууринд очих болдог. 7жилийн үргэлжилсэн их өлсгөлөнгийн үед Египетийг захирч, өөрийн үйлчилдэг Фараоныг улам хүчтэй баян болгосон юм. Тэгээд ч зогсолгүй өөрийн эцэг эх, ах нараа их өлсгөлөнгөөс аварч эцэст нь Израйлийн ардтүмэн бий болох эхлэлийг тавьсан юм.

Бурхантай эвтэй хүн нь дээрээс ирэх Бурханы мэргэн ухааныг авч хүнд хэцүү ертөнцийн амьдралд олон хүмүүсийг тайтгаруулж, ерөөлийн зам руу удирддаг. Бурханы мэргэн ухаан гэж библи дээр бичигдсэн Бурханы үг тэр чигтэй юм. Тушаалын дагуу амьдарч, хорон мууг хаяж, ариун байдлыг олох тусам зүрх сэтгэлд Ариун Сүнсний удирдамжаар дээрээс Бурханы ухаан бууж ирдэг.

Хайрт итгэгч та бүхэн,

Дээрээс ирдэг Бурханы мэргэн ухааныг авахын тулд ариун байдал, амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй ийм зүйлүүдийг сэтгэлдээ гүн шингээж, хүмүүстэй мэдээжийн эвтэй байх төдийгүй Бурхантай төгс эвтэй байх хэрэгтэй юм.

Бурхантай эвтэй байх нь Бурхан ба бид хоёрын харилцаа төдийгүй, миний бүх талбар дээр бялхтал итгэмжтэй ‘Бүх гэрт итгэмжтэй’ байхтай бүрэн холбоотой юм. Үйлчлэл, золиос, хайр ба ачит үйлсээр бүх гэрт итгэмжит байснаараа бүх хүнтэй эвтэй байх болдог. Сүнс талын эр зоригтойгоор гуйсан болгондоо хариулт авч, явсан газар болгондоо ерөөлийн үр жимс бий болгодог.

Ингэж амар тайвныг бүтээснээр Бурханы амар амгалан, ерөөл дунд байж, арвин их зөвийн үр жимсийг хурааж, Тэнгэрийн оронд нар мэт гэрэлтэй газар алдар сүр жавхланг эдлэхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

## “Дүү бид хоёр сайн сонсдог боллоо!”

Яшинтон Кан Каван ах дүү (21нас Тайланд, Бангкок Манмин хэл сонсголын бэрхшээлтэй итгэгч нарын чуулган)

Би төрөлхийн сонсголын бэрхшээлтэй тул маш хэцүү амьдралаар амьдарч ирсэн юм. Баруун чих маань огт сонсдоггүй ба зүүн чих маш муу сонсдог юм. Тэгтэл авралын зарыг хүлээн авч 2017оны 5-р сараас Тайланд Бангкок хэл сонсголын бэрхшээлтэй итгэгч нарын чуулганд явж эхлэн тэр жилийнхээ 8-р сард анх удаа Манмин зуны цуглаанд оролцсон юм.

Тэр үед маш гайхалтай нь И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг авахад зүүн чих маань сайн сонсдог болсон юм. Энэ нь надад итгэл болж, энэ жилийн зуны цуглаанд ч мөн эдгэрэл авахыг хүсэн тэмүүлсээр эрэгтэй дүүтэй (Зурагт баруун талынх)-гээ залбирлаар бэлдэн ирж оролцсон юм.

8-р сарын бны өдөр зуны цуглааны эхний өдөр,

тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуураар (Үйлс19:11-12) И Сү жин пастор индэр дээрээс нийтэд залбирч өгөхөд би индэрийн доод тал Манмин залбирлын төвийн И Буг ним удирдагчаас биечлэн залбирал авсан ба зүүн чихнээс ямар нэгэн чимээ сонсогдох мэт болж түүний дараанаас өмнөхөөсөө илүү дуу чимээг ялгадаг болсон. Халлелүяа!

Мөн талархалтай нь дүү минь ч гэсэн баруун чих сонсдог болсон ивээл авсан юм. Дүү минь зүүн чихээрээ сонсдог ч хүний ярьж байгаа үг яриаг бүрэн сонсч чаддаггүй ба хэсэгхэнийг л ойлгодог байв. Гэтэл залбирал авахад бүх биеэр нь халуу шатаж, баруун чих нээгдэж, одоо хүний үг яриаг бүрэн ойлгодог болсон. Халлелүяа!

## Хүүхэдгүй бидэнд Бурханы илгээсэн бэлэг

Би итгэгч гэр бүлд өсөж бойжсон ч ертөнцийн хүн шиг амьдардаг байлаа. Эзэн өдөр сүмдээ ирээд “Бурхан минь уучлаарай” гээд маргааш нэгдэх өдрөөс нь мөн л дахин дэлхийн зүйлтэй хутгалдан амьдарсаар дахиад Эзэний өдөр болвол “Бурхан минь уучлаарай” гэдэг байдлаар давтагдсаар байлаа.

Тэгтэл ертөнцийн зүйлээс хол байх талаар Бурхан үгийг дамжуулдаг И Жей руг тэргүүн пастортай уулзсанаас хойш байдал өөр болсон юм. Тэр хугацаанд ихээр хүсэж байсан үг сургааль байсан тул сүмд ирээд тэргүүн пасторын сургаалийг сонсвол сэтгэл минь хөнгөрч сайхан болдог байв.

Тамхиа ч гэсэн гайхалтай нь дотор муухайрдаг болоод аяндаа хаяж, амийн ус мэт үг сургаалийн сонсдог ч сүнс талын өөрчлөлт муухан ичмээр үе байсан ч Бурханы хайрыг сэтгэлдээ мэдэрч миний дотоод хүн шинэчлэгдэж байгааг мэдэрсэн юм.

2014оны хавар дөчин хоёр настайдаа нас чацуу эхнэр (Пак Юу на сүмд үйлчлэгч) тэй хамт амьдрах болсон юм. Ижил гаруй болоход хүүхэдтэй болж чадахгүй байсан ба эмэгтэйчүүдийн эмнэлэгт үзүүлж шинжилгээ хийлгэтэл саван дахь өндгөвчний гуурс бөглөрсөн байна гэсэн юм. Эхнэр минь нэртэй гэх ардын эмнэлэгт очин савны бохирдол бөглөрөлийг арилгах эм тан уусан ч ямар ч нэмэр болоогүй юм.

2016онд том эмнэлэгт дурангийн шинжилгээнд орсон ч хоёр өндгөвчний гуурс бөглөрсөн тул энгийн байдлаар жирэмслэх огт боломжгүй гэсэн



Чүэ Сон мин сүмд үйлчлэгч (47нас)

эмнэлэг рүү явсан юм. Эмч хэлэхдээ “Жирэмсэний бдахь долоо хоног болвол хүүхдийн бие бүрэлдсэн нь харагдаж, зүрхний цохилт мэдрэгдэнэ” гэсэн гайхамшигтай сайхан мэдээ сонссон юм. Халлелуяа!

2018оны 2-р сард 3.28кг эв эрүүл хүүгээ энгэртэй тэвэрч, нэрийг нь ‘Ха’ дээр эрдэнэсийн ‘Жин’ буюу Хажин гэж Бурханы өгсөн том эрдэнэ гэсэн утгатай нэр өгсөн юм. Хажинийг хайрлах тусам үргэлжид ямар ч хариу нэхэлгүй өгдөг бас дахин өгдөг Бурхан Аавба Эзэн, мөн Ариун Сүнсний хайрыг маш ихээр мэдрэх болдог. Энэ надад өгсөн хамгийн том бэлэг гэж боддог. Бүх талархал ба алдрыг Ариун Гурвал Бурхандаа өргөж, залбирч өгсөн тэргүүн пастортаа баярлалаа.

сэтгэлээр унах үг л сонссон юм. Тэгээд л бид хоёр Бурхандаа бүх талаар найдан зуурахаар шийдсэн ба Бурхан Аав яг энэ үеийг хүлээж байсан мэт байлаа.

2017оны 5-р сард бид хоёр ‘Хүүхэдтэй болох ерөөл’-г сэтгэлдээ агуулж, мацаг барин бэлдэж, гэрийн мөргөл хийхэд Бурханаас маш ивээл авсан юм. Энэ хугацаанд маш их эрх мэдэлт хүчний гэрчлэлийг үзсэн ч бодит байдал дээр итгэлээ үзүүлж чадахгүй байдлаа эргэн харан гэмшиж, амийн сургааль ба амьд орших Бурханы баталгаа дүүрсэн өргөө сүм рүү удирдсан ивээлд талархан уйлах үе ч байлаа.

Тэгээд нэг сарын дараа бие нь эвгүй байдлыг мэдэрсэн эхнэр минь жирэмсэний тестээр шалгаж үзэхэд хоёр зураас гарсан ба эмэгтэйчүүдийн

## “Бамбай булчирхайн үйл ажиллагаа доголдох хам шинж өвчнөөс цэвэрхэн эдгэрсэн”

Ким Хю жин эгч дүү (24нас)



2018оны 4-р сараас бие маань маш сульдсан юм. Ажил дээрээ ч ажил сайн явах болохоор сэтгэл ч тавгүй дээрээс нь “Ямар их таргалж байнаа?” гэсэн үг байнга шахуу сонсох хэмжээний бүх биеэр хавагнаж, маш их ядардаг байв. Хүзүү хоолой ч хөөж хавдан нэг найз маань “Хүзүү чинь хийтэй хаймар шиг яагаад бамбагар болчив?” гэсэн юм. Эмнэлэг рүү явж шинжилгээ хийлгэтэл Бамбай булчирхайн үйл ажиллагаа доголдох хам шинж гэсэн юм.

Эмч хэлэхдээ Бамбай булчирхайн дааврын хэмжээ ингэж багассан байхад яаж ажил хийгээд байсан юм гэж гайхаж, “Эм ууж дааврын хэмжээгээ зохицуулах хэрэгтэй. Эм уухгүй бол дааврын хэмжээ шууд буурч дахин өвчин сэдэрх тул байнга энэ эмийг уух хэрэгтэй” гэсэн юм.

Бурханы өмнө итгэлээрээ эдгэрэхийг хүсч байгаа ч ажил хийж чадахааргүй хэцүү байсан тул эм ууж эхлэсэн юм. Тэгсэн ч бамбайн дааврын хэмжээ бага тул эмийн тоо давтамжийг нэмж хэвийн хэмжээнд хүрсэний дараа ч үргэлжлүүлэн уух хэрэгтэй болсон юм. Бие маань урьдын адил хэцүү хэвээр бага багаа сулбагар болж байв. Гэсэн ч ойртож буй Манмин зун цуглаанд оролцож заавал эдгэрье гэсэн бодол хүчтэй болов.

Зуны цуглааны яг өмнөх өдрөөс эхлэх “Эм уухгүй байсан ч болох юм байна” гэсэн сэтгэл төрж, итгэлээр үйлдэж эхлэсэн юм. 8-р сарын 6зуны цуглааны эхний өдөр тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуураар (Үйлс19:11-12) сургаал заагч И Сү жин пастор индэр дээрээс өвчин эдгээх залбирал хийж өгсөн юм. Би ч чин сэтгэлээсээ залбирал авч, зуны цуглаанаас хойш бие хөнгөрч, ядарч сульдахыг бараг мэдрэхгүй болсон юм.

Би илүү төгс эдгэрэхийн тулд 10-р сарын 8наас эхлэн 2удаагийн онцгой Даниел залбиралд оролцон залбирал хийсэн юм. Тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуурыг цээжиндээ тавин залбирахад зүгээр л нулимс урсаж байлаа.

Бурхан миний сэтгэлийг тайтгаруулж аргадаж байгаа мэт байв. Энэ хугацаанд залбирал тасалж байсан, төгс итгэж чадаагүйдээ гэмшиж, өдөр бүр гар утсаараа “Шинэ өдөр эхлэх залбирал” “Өвчин эдгээх залбирал”-г авч ажилдаа явдаг болов.

Тэгээд 12-р сарын 10нд эмнэлэгт шинжилгээ хийлгэтэл дааврын тоо хэвийн хэмжээнд хүрсэн байлаа. Эмч надад эмээ тасалж огт болохгүй гэсэн ч би итгэлээр 4сар орчим эм уухгүй байсан ба энэ нь зөвхөн Бурхан эрх мэдэлт хүчээр төгс болсон зүйл юм. Халлелуяа!

Эзэний үнэт цусаар өвчнийг цэвэрхэн эдгээж өгч, Бурханыг хайрлан ерөөлт амьдралаар амьдрах замаар хөтөлж өгсөн Ариун Гурвал Бурхандаа бүх талархал алдрыг өргөө.

Эмнэлэгийн шинжилгээний хариу			
검사 항목	검사	검사 항목	검사 값
TSH (2013.2.12)	92.260(uIU/ml)	TSH (2013.2.12)	2.070(uIU/ml)
Free T4 (2013.02.12)	0.39(ng/dL)	Free T4 (2013.02.12)	0.98(ng/dL)
T3 (2013.02.12부터)	0.75(ng/mL)	Albumin(2013.03.01)	4.6(g/dL)
		Bilirubin(Total)	0.65(mg/dL)
(REMARK)		(REMARK)	
검사일시: 2018년 04월 20일 12시 42분 Bill NO: 272828		검사일시: 2018년 12월 04일 12시 07분 Bill NO: 298130	
출원일자: 2018년 05월 03일			

Бамбай булчирхайн идэвхитэй дааврын хэмжээ хэвийн хэмжээнээс 30дахин багассан байсан ч залбирал авсаны дараа дааврын хэвийн байдалд хүрсэн байгаа нь.

### УБ Ариун баярт мэдээ чуулган

#### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

#### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

#### Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048  
http://www.manmin.org/english  
www.manminnews.com  
e-mail: manminnews@manmin.kr  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин